



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2022 оны 2 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар
хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай

1. “Итгэлт хүлэг” ХХК-ийн нэхэмжлэлтэй, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга Д.Лхамжав, Ашигт малтмал, газрын тосны газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Р.Энхтайван нарыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1-д заасан хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, тэмдэглэл, хуулбар хийх, шүүх хуралдаанд оролцох, нотлох баримт гаргаж өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргах хүсэлт гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих, мөн хуулийн 28.2-т заасан хариу тайлбар гаргах, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах эрхийг олгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ